



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар A/43

Улаанбаатар хот

┌ Сургалт зохион байгуулах тухай ─┐

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байшин, орон сууцны тооллогын Хангайн бүсийн сургагч багшийн сургалт зохион байгуулах, хяналт хийх бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сургалт болон хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжүүлэх ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтад зарцуулагдах зардлыг холбогдох төсвөөс гаргахыг Тамгын газрын Санхүүгийн хэлтэс /Д.Батсүх/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ч.ЦЭВЭГДОРЖ

Үндэсний статистикийн хорооны
Тамгын газрын даргын 2019 оны
~~7~~ дугаар сарын ~~24~~-ны өдрийн
~~А/43~~ дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

Байшин, орон сууцны тооллогын Хангайн бүсэд сургагч багшийн сургалт зохион байгуулах, хяналт хийх бүрэлдэхүүн

Багийн ахлагч:

Т.Болор-Эрдэнэ Хүн ам, нийгмийн статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга

Багийн гишүүн:

Ч.Бат-Эрдэнэ Хүн ам, нийгмийн статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллогын товчооны ахлах статистикч

О.Өүжингэ Хүн ам, нийгмийн статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

Т.Ариунсайхан Хүн ам, нийгмийн статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

Б.Оюухорол Хүн ам, нийгмийн статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

Г.Жаргал Мэдээллийн технологийн газрын Программ хангамжийн албаны референт

БАЙШИН, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ХИЙЖ АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Зорилго:

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын хүрээнд хийгдэх Байшин, орон сууцны 2019 оны тооллогын сургагч багшийн сургалт зохион байгуулах, тооллогын бэлтгэл ажилд хяналт хийх, заавар, зөвлөгөө өгөхөд энэхүү удирдамжийн зорилго оршино.

Байршил: Архангай аймагт

Хугацаа:

- 2019.08.08-08.13-ны өдрүүдэд

Үйл ажиллагаа:

- Хангайн бүсийн аймгуудын ажилтнуудад тооллогын бэлтгэл үе, тоолох үе, тооллогын дараах үеийн зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалтын прорамм хангамж, ХАӨМС-г БОСТ-ын хяналт болоод явц, мэдээлэл цуглуулалттай хэрхэн уялдуулах, асуулгын хуудас, үзүүлэлт, ойлголт, тодорхойлолттой холбоотой асуудлуудаар сургалт зохион байгуулах
- Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд одоогоор хийгдсэн ажил болон цаашид хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой ажлуудад хяналт тавьж, заавар, зөвлөгөө өгч ажиллах
- ХАОСТ-2020 зохион байгуулахтай холбоотой сургалт, мэдээлэл өгөх

Хүлээгдэж буй үр дүн:

Тус сургалт, хяналтын үр дүнгээр тооллогын бэлтгэл ажлуудыг хангана. Үүнд:

- Тооллогын сургагч багш нар бэлтгэгдсэн тул тоологч, шалгагчийн сургалт зохион байгуулахад бэлэн болсон байна.
- БОСТ-той холбоотой нэгдсэн мэдээлэл, ойлголттой болно.